

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.06.30

Цагааннуур сум

№	Мөрийн хөтөлбөрийн заалт	Хэрэгжилт	Хувь
Нэг. “Ковид-19” болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого			
1.1	“Ковид-19” болон бусад халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	2021-2022онд Эрүүл мэндийн төв нь 26 орон тоотой ажиллаж байсан. “Ковид-19” цар тахлын үед ажиллах эмч мэргэжилтний судалгааг гаргасан. 2021 онд өөрийн хүсэлтээр гарсан их эмч 2, сувилагч 1, бага эмч 1, одоо 22 орон тоотой ажиллаж байна.	90%
1.2	“Ковид-19” халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг урьдчилан нөөцлөх, түргэвчилсэн оношлуур болон РТ-ПСР төхөөрөмжөөр хангана.	“Ковид-19” халдварт цар тахлын үед хэрэглэгдэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг урьдчилан нөөцлөх, түргэвчилсэн оношлуураар тасралтгүй ханган ажилласан.	90%
1.3	Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар өөрийн Эрүүл мэндийн төвийн Tsagaannuur EMT цахим хаягаар дамжуулан ухуулга, сурталчилгааг хийж, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.	90%
1.4	“Ковид-19” цар тахлын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг эн түрүүнд шийдвэрлэж, үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах нөхцөл боломжоор хангана.	Хариу арга хэмжээ авах, эмнэлгийн бэлэн байдлыг хангагдсан. Шаардлагатай тохиолдолд нөөц нэмэгдүүлэх зорилгоор 3 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан	90%
1.5	Томуу, томуу төст өвчин, улаанбурхан, улаанууд зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулах ажлыг зохион байгуулна.	2021 оны 4-р улиралд Томуу, томуу төст өвчний дархлаажуулалтанд 2 настай 14, 3-5 настай 152, 6-11 настай 368 хүүхэд, нийт 534 хүүхдийг хамруулсан. Амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 10-р сард зохион байгуулна.	90%

1.6	“Ухаалаг цахим сургалт”-ын орчинг нэмэгдүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, багш нарын мэдлэг ур чдвар, эцэг, эхчүүдийн оролцоог дээшлүүлнэ.	Өдөр тутмын танхим болон цахим ирцийн мэдээллийг бага, дунд, ахлах ангийн бүх багш нарт нээлттэйгээр Google sheet- ээр хуваалцах төдийгүй, эцэг эхийн цахим группэд мэдээллийг хуваалцаж, 7 хоног, сар, улирлаар нэгтгэн мэдээллэж эргэх холбоотой ажиллалаа. Мөн багш нар АУБ-даасан анги 25 бүлэг, АУБ-Эцэг эхчүүд-36, АУБ-мэргэжлийн баг нар-79, мэргэжлийн багш-суралцагч /давхардсан тоо-123/ группээр холбоо тогтоож ажилласан ба багш нар 118 удаагийн цахим сургалт, 162 сурагч төрөл бүрийн цахим сургалтуудад хамрагдсан байна.	90%
1.7	Нийгмийн халамж, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах иргэдэд банк, төлбөр тооцооны цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.	Нийгмийн халамжийн үйлчилгээ Ехаламж цахим системд холбогдсон.	90%
1.8	Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тусламж дэмжлэг, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.	Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын явуулын үйлчилгээ үзүүлэх баг сумын удирдлагуудад хүүхдийн эрх хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр цаашдын ажил арга хэмжээг төлөвлөх чиглэлд санал өгч, газар дээр нь зөвлөн туслах үйлчилгээг 3 удаа үзүүлсэн.	90%
1.9	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Зорилтот бүлгийн 236 хүнд урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, өвчлөл илэрсэн 25 хүнийг эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн. Асаргаа шаардлагатай 4 ахмад настан, 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2 хүүхдийг байнгын асаргаанд оруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй 9 иргэнийг сэргээн засах тусламж үйлчилгээ, 12 иргэнийг өдрийн эмчилгээнд оруулсан.	90%
1.10	Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангана.	Үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын хоол хүнс, нэг удаагийн хувцас хэрэгсэл, шатахуун, бичиг хэрэг, халаалт зэрэгт Засаг даргын нөөц хөрөнгөөс 41.329.650 төгрөгийг зарцуулсан байна.	90%
1.11	Коронавируст халдвар /Ковид-9/-ын эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогыг орон нутагт зохион байгуулж,	Улс, аймаг, сумын Онцгой комиссоос үйл ажиллагааг нь хязгаарлаагүй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид халдвар хамгааллын дэглэмийг баримтлан	90%

	жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	хэвийн горимд ажиллаж байна.	
Хоёр.Хүний хөгжлийн бодлого			
2.1.Эрүүл мэнд. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх оношилгоо, эмчилгээнд “Ухаалаг цахим” технологийг нэмэгдүүлнэ.			
2.1.1	Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг тасралтгүй зохион байгуулна.	<p>2021 онд хүн амын дунд халдварт бус өвчнөөс /Артерийн даралт ихсэх өвчин, Чихрийн шижин хэв шинж-2, элэгний хорт хавдар, умайн хүзүүний болон хөхний хорт хавдар/-аас урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийг тасралтгүй зохион байгуулсан.</p> <p>2021 оны 11-р сард алслагдсан багийн хүн амд ковидын дархлаажуулалт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг хийж ажилласан. Үзлэгт 1,2,3-р багийн 976 иргэнийг хамруулж, 1200 ширхэг гарын авлага тараасан.</p> <p>2021 оны 12-р сарын 3, 4-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газраас 10 хүний бүрэлдэхүүнтэй нарийн мэргэжлийн эмч нарын баг ирж, Ковидын дараах үзлэг хяналтыг хийв. Үзлэгт нийт 284 хамрагдсанаас уушгины рентгенд 241, хүүхдийн эмчийн үзлэгт 52, сэтгэцийн эмчийн үзлэгт 95, дотор эмчийн үзлэгт 208, мэдрэлийн эмчийн үзлэгт 140 хүн тус тус хамрагдсан.</p> <p>2022 оны хагас жилийн байдлаар сумын хэмжээнд Халдварт бус өвчний илрүүлэх дараах үзлэг явагдаж байна.Үүнд</p> <ul style="list-style-type: none"> ➤ Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 800 буюу 24.4% ➤ Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлгийн үзлэгт 742 буюу 47.4% ➤ Элэгний хорт хавдар эрт илрүүлгийн үзлэгт 182 буюу 11.6% ➤ Урьдчилан сэргийлэх үзлэгт 814 буюу 19.4% ➤ Умайн хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 32 буюу 13.5% <p>Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 88 буюу 24.4%-ийг тус тус хамруулсан байна.</p>	90%
2.1.2	Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх	“Эрүүл идэвхитэй амьдрал” сэдэвт 1 удаагийн явган	90%

	<p>“Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх”, “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>аяллыг 2021 оны 6 сард зохион байгуулж нийт 56 ахмад хамрагдсан.</p> <p>Халдварт өвчнөөс сэргийлэх сургалтаар Явуулын 3 удаа 258 иргэн, амбулаториор 10 удаа 345 иргэн, хэвтэн эмчлүүлэгчид 65 удаа 187 иргэн, гарын авлага 5 төрлөөр 2578 ширхэгийг тараасан байна.</p> <p>2021 оны 02 сард “Хавдрын эсрэг Дэлхийн өдөр” өдрийг тохиолдуулан хавдартай иргэдийн судалгааг шинэчилж, хавдраар оношлогдсон, эмчлэгдэж байгаа 35 иргэдийн гэрээр эргэлт хийж зөвлөгөө өгсөн.</p> <p>“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг идэвхжүүлэх сарын аян зарлаж хөдөө алслагдсан 1,2,3-р багийн өрхүүдээр 15-аас дээш насны 987 иргэний Элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээ болон элэгний хорт хавдар илрүүлэх үзлэгт 40-65 насны 569 иргэдийг хамруулж, зөвлөгөө өсөн. Хавдрын эсрэг гарын авлагыг 3 төрлийн 2155 ширхгийг тараасан.</p> <p>2021 оны 8 сард “Харшлаас сэргийлэх” сарын аян өрнүүлж, Эмнэлгийн талбайн зэрлэгийг устгаж Харшлаас сэргийлэх гарын авлага 325 ширхгийг тарааж, 3 удаагийн сургалтын материалыг цахимд байршуулан 715 хүний хандалт авсан.</p> <p>2021 оны 5 сарын 15-ны Гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” аяныг зохион байгуулж 1,2,3-р багийн алслагдсан өрхөөр 3 удаагийн эргэлт хийж 76 өрхийн 325 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 3 удаагийн сэдвээр сургалт явуулан 525 ширхэг гарын авлага тараасан.</p> <p>2022 оны хагас жилийн байдлаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.Үүнд</p> <ul style="list-style-type: none"> ➤ Эхчүүд, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, манлайллыг түгээх орон нутаг дахь эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн удирдлага төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран уялдаа холбоог сайжруулах үүднээс Цагааннуур сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран
--	---	---

		<p>Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг 2022.03.06-нд зохион байгуулсан. Уулзалтанд Гэр бүлийн үнэ цэнэ сэдэвт лекторын лекц тавьж, 10 эмэгтэйчүүдийг сумаас шагнах үйл ажиллагаа явуулсан.Уулзалтанд нийт 156 эмэгтэйчүүд орлцсон</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/780 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээ” болон “Дэлхийн эрүүл мэндийн өдрийг угтан “Эрүүл идэвхитэй амьдрал” уриан дор Цагааннуур, Ерөө бүсийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын дунд олон төрөлт спорт тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээнд байгууллага тус бүр 10 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдаа оролцууллаа. Тэмцээнд нийт 11 сумын 110 эмч, эмнэлгийн ажилчид оролцож, нөхөрсөг уулзалт, тэмцээн зохион байгуулсан.</p>	
2.1.4	Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд E-hospitals цахим үйлчилгээг 6-р сараас эхлэн нэвтрүүлэн ажиллаж байна. Цаашид “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд тулгуурлан хүн төвтэй эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлэх замаар хүн амын бүлгийн хувьд 5 хүртэлх насны хүүхэд, 5-18 насны хүүхэд, 18-аас дээш насны хүмүүсийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж байна. Эхний хагас жилийн байдлаар5-18 насны 500 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	90%
2.1.5	Мэргэжлийн өндөр, ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтныг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулах, гадаад дотоодод туршлага судлуулах, давтан сургах арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	<p>2021 онд 2 эмнэлгийн мэргэжилтнийг шинээр авч ажиллуулсан. Орон байраар хангах асуудлыг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран шийдвэрлэж байна.</p> <p>2021 онд эмнэлгийн эмч ажилтнуудын мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлагын талаар 5 удаагийн сургалтанд 26 эмч ажилтныг хамруулсан.</p> <p>2022 оны эхний хагас жилийн байдлаар шинээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн авч ажиллуулаагүй.</p> <p>2022 онд эмнэлгийн эмч ажилтнуудын мэргэжлийн ёс</p>	90%

		зүй, харилцаа хандлагын талаар 2 удаагийн сургалтанд 24 эмч ажилтныг хамруулсан.	
2.1.7	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож “Эрүүл хүүхэд-Эрүүл ирээдүй” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж эрүүлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 онд 2-12 насны 525 хүүхдийг амны хөндийн үзлэгт хамруулж, нийт хүүхдийн 55% нь өвчтэй илэрч, эрүүлжүүлэх арга хэмжээг авсан. 2021 оны 12-р сард “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотоос шүдний нарийн мэргэжлийн эмч нарыг авчирч, өвчлөл илэрсэн 2-12 насны 35 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Сургууль, цэцэрлэгийн насны 2-11 насны 534 хүүхдийг томуугийн дархлаажуулалтанд хамруулсан. 2022 оны хагас жилийн байдлаар ЕБС-ын 1-12-р ангийн 1050 хүүхдийг амны хөндийн үзлэгт хамруулснаас 464 хүүхдийн 995 шүдний өвчлөлийг илрүүлсэн. Илэрсэн өвчлөлтэй хүүхдүүдийг эрүүл мэндийн төвийн хяналтанд бүртгэж, эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллаа. Өвчлөлтэй илэрсэн хүүхдийн эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	90%
2.1.8	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	2021 онд эмнэлгийн эмийн сан нь Монгол Эм Импекс Концерн ЭХНБ-тай гэрээ байгуулан хэвтэн эмчлүүлэгчдэд болон яаралтай тусламжид тасарсан эм тариа, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг татан авч ажиллаж байна. 2021 онд хөнгөлөлттэй эмийн жороор нийт 605 хүнд үйлчилсэн байна. 2022 онд 301 нэр төрлийн нөөцтэй байна.Тендерт 258 нэр төрлийн эмийн нөөцтэй. Эмийн хугацаанд хяналтын самбар хөтөлдөг. Хэрэглээ зарцуулалтыг сар бүр орлого зарлага санхүүгийн тайлангаар зарцуулалт нь гардаг.Нөхөн хангалтыг сар бүр татан авалт хийж явдаг. Эмийн хангалт нөөцийг чанарын шаардлага хангасан магадлан итгэмжлэгдсэн Сэлэнгэ аймаг Монгол Эм Импекс концерн, УБ хотын Ундрах чанар, Дархан-Уул аймгийн Монос-Дархан эм ханган нийлүүлэх байгууллага байгуулагатай гэрээ хийж бүрдүүлдэг.	90%
2.1.9	Зарим сумын Эрүүл мэндийн төвүүдийг шүдний эмчээр хангаж, шүдний кабинеттай болгоно.	2022 онд шүдний кабинетыг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахаар төлөвлөж байна.. Тус сумын эрүүл мэндийн төв нь 2022 оны 04 сард	70%

		Цагааннуур сум – 5147, Түшиг сум -1887, Зүүнбүрэн сум -3011, Шаамар сум – 2296 нийт 12341 хүн амыг хамруулах боломжтой шүдний кабинет ажиллуулах төслийг болосвруулан сумдын бүсчилсэн уулзалтанд УИХ-ын Ж.Эрдэнэбат гишүүнд танилцуулж, ЭМГ-т файлаар илгээсэн.	
2.1.14	Эмч, эмнэлгийн ажилтнуудын тогтвор суурьшилтай нөхцөлийг хангаж, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ.	<p>2021 онд 2 эмнэлгийн мэргэжилтнийг шинээр авч ажиллуулсан. Орон байраар хангах асуудлыг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран шийдвэрлэж байна.</p> <p>2021 онд эмнэлгийн ёс зүйтэй холбоотой 1 санал гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэж, санал гомдлыг барагдуулсан.</p> <p>2022 оны хагас жилийн байдлаар нийт 24 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 оны 06 сард 1 асрагч өндөрт настны тэтгэвэрт гарч, шаардлагатай тэтгэмж, урамшууллыг олгосон.</p> <p>2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Эмч, эмнэлгийн ажилчдын байр барих ажлыг энэ оны 6 сарын дундуур эхлэхээр ажиллаж байна.</p>	90%
2.2. Боловсрол			
Хөгжлийг түүчээлэх чадвартай монгол хүнийг хөгжүүлнэ.			
2.2.1	Ерөнхий боловсролын сургуулийн “Мэргэжилт сонголт” арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, гадаад, дотоодын их, дээд, ерөнхий боловсролын сургууль болон бусад боловсролын байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана.	Ахлах ангийн АУБ нар ангийн сурагчдадаа “Мэргэжлийн нэ цэнэ”, “Мэргэжил сонгохын учир”, “Мэргэжил гэж юу бэ” сэдэвт сургалт хичээл, зөвөлгөөг өгч ажилласан ба НТБ-оос 12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан сургалтуудад сурагчдыг хамрагдсан ба үүнд давхардсан тоогоор 172 сурагч хамрагдсан байна.	90%
2.2.2	“Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	“Сургалтын байгууллага- тоног төхөөрөмж” арга хэмжээний хөтөлбөрийн дагуу байгалийн ухааны хичээлүүдийн туршилт, дадлага явуулах анги танхим кабинеттай болгох ажлын хүрээнд биологи, газар зүй, математикийн кабинетийн тоног төхөөрөмжөөр, хангагдсан байна. Мөн хичээлийн Б байрны 5 ангийн сурагчийн ширээ сандлыг шинэчлэн нийлүүлэгдсэн байна.	90%

2.2.3	“Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулна.	БМДИ-ийн анхны жилийн сургалтад 4 багш цахимаар Боловсролын газар, сум орон нутаг, байгууллагаас зохион байгуулсан нийт 28 удаагийн сургалтад давхардсан тоогоор 420 багш ажилтан хамрагдсан.	90%
2.2.4	Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулна.	БМДИ болон Боловсролын хүрээлэн, БШУЯ-аас “Сургалтын сайжруулсан хөтөлбөр”-ийг хэрхэн хэрэгжүүлэх, сургалтын агуулгын хоцрогдолыг арилгах үүднээс Сэлэнгэ аймгийн хэмжээнд “Мэргэжлийн бүлэг” нээж багш нар болон арга зүйчид арга зүйн сургалт семинар, хэлэлцүүлэгт хамрагдаж, хоцрогдсон агуулгаар сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан 42 хичээл бэлтгэж хүргэлээ. Боловсролын газраас арга зүйч, багш нарт хүүхдийн ахицын үнэлгээг хийх, танхим болон тахимын бус сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан бөгөөд 7 багш арга зүйч эрхлэгч хамрагдаж хүүхдийн ахицын үнэлгээг гаргалаа. Хичээлийн жилд хүүхдүүдийн ерөнхий чадвар чадамжийг хяналтын хуудас,Рубик үнэлгээ, чөлөөт ажиглалтын тэмдэглэл, дасгал даалгавар зэргээр түвшин тогтоосон. Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ 83%-тай байна.	90%
2.2.6	Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хүүхдийн суралцах үйлийн онцлогт тохируулан дасгал даалгавар боловсруулан ганцаарчилсан хөтөлбөр хэрэгжүүлж байна. Шинэ баригдсан барилга стандартын налуу замтай. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд зориулан 6 бүлгийн ариун цэврийн өрөөний суултуурын хажуу хаалтад 24 ширхэг бариул суурилуулсан. Цэцэрлэгт 3 болон 4 настай хөнгөн хэлбэрийн харааны бэрхшээлтэй 2 эмэгтэй суралцагч байгаа. Энэ хичээлийн жилд зөвхөн 4-5 настангуудыг цэцэрлэгт танхимын болон цахим хэлбэрээр хамруулах журам гарсантай холбоотойгоор дээрхи 2 хүүхдэд гэрээр нь дасгал даалгаврын эмхтгэл боловсруулан хүргүүлсэн.	90%
2.2.7	Ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр, Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль болон Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулиудын	2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4,9 тэр бум төгрөгийн өртөг бүхий хичээлийн 3 дугаар байрны өргөтгөлийн асуудал шийдвэрлэгдсэн. Асуд констракшн	70%

	хичээлийн байрны өргөтгөл, зарим шаардлагатай сургуулийн спорт заал, дотуур байрыг шинээр барих, сургууль, цэцэрлэгүүдийн их засварын ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ.	гүйцэтгэгчээр нь ажиллаж байна.	
2.3.Биеийн тамир, спорт			
Бүх нийтийн биеийн тамирыг дэмжих замаар иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дадал хэвшлийг бий болгоно.			
2.3.1	“Спортлог Сэлэнгэчүүд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БТСУХ-оос Цахим спорт арга хэмжээ зохион байгуулагдан алхалт, гүйлтийн сарын аян зарлагдан сумын хэмжээнд 60 иргэн хамрагдав. Мөн энэ арга хэмжээний хүрээнд олон төрөлт дасгал, аэробек, хийн дасгалын төрлүүдээр орон даяар “Цахим гимнастрада” уралдаан зарлаж Цагааннуур сумын ахмадын баг хийн дасгал цоглог шугаман бүжиг болон, сургуулийн сурагчид аэробекийн төрөлд оролцлоо.	90%
2.3.2	“Эрүүл иргэний төлөө хамтдаа” хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, үр дүнг тооцно.	06-р сарын 02-ны өдрөөс 06 сарын 30-ны өдөр хүртэл Биеийн тамир, спортын улсын хорооноос цахим хэлбэрээр зохион байгуулсан “Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аянд ахмадууд нэгдэж өглөө бүр 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр алхалт хийсэн. ЕБС-н 12а ангийн сурагчидтай хамтран “Алхам алхмаар” алхалтын аяныг зохион байгуулсан. Давхардсан тоогоор 60 иргэн оролцсон. Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилга,Биеийн тамир,спортын улсын хорооноос зохион байгуулж буй “ Илүүдэл жингүй–Эртэч Монгол” аян зарлагдаж Суманд давхардсан тоогоор 1756 иргэд хамрагдлаа.	90%
2.3.3	Аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	Сэлэнгэ бүсийн төрийн албан хаагчдын нөхөрсөг тэмцээн зохион байгуулагдаж Цагааннуур сумын ЗДТГ-ын албан хаагчид амжилттай оролцож багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ. Аймгийн засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлт тэмцээн тодохойгүй хугацаагаар хойшилсон байна.	70%
2.3.6	Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхижуулах, мерит зарчмын дагуу шат шатны байгууллагуудад шатлан ажиллуулах бодлого хэрэгжүүлнэ.	Биеийн тамир улсын хорооноос зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.”Эрүүл мэндийн цахим гүйлт”, Дасгал хөдөлгөөн хийцгээ”, Эрүүл амьдралын хэв маягт”, алхам алхмаар “Цахим гимнастрада” аэробек	90%

		сургалтанд хамрагдсан.	
2.3.7	Үндэсний спортын төрлөөр хичээллэгсэд болон сонирхогчдын тоог нэмэгдүүлж, хүүхэд, залуучуудад өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	ХАА-н ажиллагсадын баярын өдрийг тохиолдуулан Монгол улсын харцага Б.Орхонбаярт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд улс, аймаг, сумын цолтой 32 бөх барилдаж авхаалж самбаагаа сорилоо.	90%
2.3.8	Тамирчдын ур чадварыг ахиулж, улс, тив, дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг бэлтгэнэ.	Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 10 дугаар сараас эхлэн 3 төрлийн секц дугуйланд 50 гаруй сурагчид хамрагдаж байна.	90%
2.3.9	Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулна.	<p>Ардын хувьсгалын 100, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90, Монгол Улсад орчин цагийн Биеийн тамир, спортын хөдөлгөөн үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан "ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМ"-д сумын 19-с дээш насны 35 иргэн спортын 3 төрөлд оролцсон. Сэлэнгэ "Цасны баяр"-ын өртөөт марафон арга хэмжээнд сумаа төлөөлөн 6 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид оролцсон.</p> <p>Улсын ургацын 2 удаагийн аварга " Сэлэнгэ тариа" ХХК- ийн нэрэмжит сумын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн Спорт цогцолборт явагдаж тэмцээнд эрэгтэй 9 баг, эмэгтэй 6 баг өрсөлдөж, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээнд хурд хүч, ур чадвараараа бусдыгаа манлайлан оролцсон тамирчдаас эрэгтэй, эмэгтэй төрөлд тус бүр нэг "Шилдэг довтлогч" , "Тэгш тоглогч" шалгарууллаа</p> <p>Улсын ургацын 7 удаагийн аварга "Товхонхан" ХХК- ий нэрэмжит сумын аварга шалгаруулах волейболын тэмцээн 03-р сарын 12-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд эрэгтэй 7 баг, эмэгтэй 11 баг тамирчид оролцож, хурд хүч, авьяас чадвараа сорин өрсөлдлөө.</p>	90%
2.4. Соёл, урлаг			
Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэн төлөвшүүлнэ.			
2.4.1	Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэн, улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.	"НААРИЙЧ БИЙЛИЙЧ" өвлөн уламжлагчдын цахим наадамд өвлөн уламжлагч МТААвьаастан Ч.Шинэбилэг аймгийн бүтээлч ардын авьяастан Доржсүрэн нарын	90%

		Хотон үндэстний бий биелгээгээр амжилттай оролцлоо.	
2.4.2	“Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам”, “Монгол өв соёл-Монголын дархлаа”, “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулан өв соёлыг түгээн дэлгэрүүлнэ.	Хэргэжиж эхлээгүй байна.	0%
2.4.3	“Сэлэнгэ соёл” үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	Соёлын бүтээлч сар аяны хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор эмэгтэйчүүдийн дунд гар урлал бэлэг дурсгалын цахим уралдаан зарлаж 4 хүний бүтээлүүдээр үзэсгэлэн гарган амжилттай оролцсон оролцогчдыг шагнаж урамшуулсан.	90%
2.4.4	Монгол өв соёлоо ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авьяастнуудыг алдаршуулна.	Цагааннуур сумын соёлын төвийн цахим хаягаар дамжуулан соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нийт-6 хүнийг алдаршуулсан..	90%
2.4.7	“Сэлэнгэ сайхан нутаг”-ийн байгалийн өвийг баримтжуулж, хамгаалан түгээн дэлгэрүүлнэ.	Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ амйаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан сурагчдын дунд Сэлэнгэ сайхан нутаг гар зургийн уралдааныг зохион байгууллаа. 6-9 анги 10-12ангийн нийт- 8хүүхэд оролцлоо.	90%
2.4.8	“Цахим номын сангийн сан хөмрөгийн үйлчилгээ”-ний хэрэглээг нэмэгдүүлнэ.	Иргэд олон нийт болон хүүхэд залуучууддаа “Монголын нууц товчоог” цувралаар хүргэсэн. “үлгэрээ сонцгооё” сургамжит яриан үлгэрийг 4 удаа явуулсан 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нэг сая төгрөгний 66 ном худалдан авч номын фондыг баяжууллаа	90%
2.4.9	Аймгийн Музей болон орон нутгийн судлах танхимд эх орныхоо түүх соёлыг таниулах зорилгоор хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон үзмэрүүдээр баяжруулж, виртуал хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Цагааннуур суманд байгаа түүх соёлын газруудыг зургаар болон видео хэлбэрээр дэлгэрэнгүй ард иргэдэд цахим хэлбэрээр хүргэлээ.	90%
2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого:			
Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжиж, иргэн бүрт хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгоно.			
2.5.1	Гэр бүл, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, “Хүчирхийлэлгүй аймаг” болох бодлогыг хэрэгжүүлнэ.	2021 онд тус суманд 108 дуудлагын утсанд болон цагдаагийн байгууллагаар дамжин ирсэн, өөрсдийн илрүүлгээр нээсэн нийт 13 кейс байгаагаас 8 кейс бүрэн хаагдсан ба үлдсэн 5 кейс дээр ажиллагаа үргэлжлэн хийгдэж байна Гэр бүл, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	90%

		<p>ажлыг бүх шатанд зохион байгуулж, “Хүчирхийлэлгүй аймаг” болох бодлогын хүрээнд 04-р сард Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах “Хүүхдэд ээлтэй хүчирхийлэлгүй сум” сэдэвт цахим сургалтад сумын хамтарсан багийн 11 гишүүнийг хамруулсан.</p> <p>2022 онд хамтарсан багийг бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, шинээр гишүүн болсон албан хаагчидтай нууцын гэрээ байгуулж ажжиллаж байна. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох-1, хүүхэд хамгааллын кейс – 7 дээр ажиллаж байгаагаас 108 дуудлагын утсанд ирсэн-4, хүүхэд хамгааллын багаар дамжин ирсэн-2 кейс байна.</p> <p>Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ГБХЗХГ-аас зохион байгуулагдсан НАМС-ын сургалт, НБХМэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, “Хүүхэд хамгааллын кейс менежмент”, “НАМС-ыг ашиглах нь” зэрэг сургалтуудад хамрагдсан.</p> <p>Хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчилах, хамтран ажиллахад хүн бүрийн оролцоо маш чухал гэдгийг сурталчлах зорилгоор сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сургалтыг зохион байгуулсан.</p>	
2.5.2	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажлыг зохион байгуулна.	6-11-р ангийн сурагчдад “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 368 сурагч хамрагдсан	70%
2.5.3	Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	<p>Сургууль цэцэрлэгийн амралт эхлэхтэй холбогдуулан ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, цагийг зөв үр бүтээлтэй өнгөрөөх талаар зөвлөмж, гарын авлага тарааж, мэдээлэл өгөх талаар сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч нарт чиглэл өгч ажилласан. Чиглэлийн хүрээнд нийгмийн ажилтан, арга зүйч, анги удирдсан багш нар өөрийн байгууллагын цахим хаяг, ангийн чат хаягаар мэдээлэл, зөвлөмжүүдийг тогтмол хүргэн ажиллаж байна.</p> <p>2022 онд Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй</p>	90%

		<p>баяя уриалгуудийг цахим орчинд түгээн ажиллаж байна</p> <p>6-11-р ангийн сурагчдад ҮЕ ТЭНГИЙН ДАРАМТ ДЭЭРХЭЛХЭЛТ, ГАДУУРХАЛТ сэдвээр сургалт зохион байгуулсан. Нийт 368 сурагч хамрагдсан</p> <p>“Хүүхдийн аюулгүй орчны төлөө бид нэгдэж байна” аяныг ултаж анги бүлгүүдийн дунд “Kindergarten” зохион байгуулан явуулсанаар цэцэрлэгийн эргэн тойрондох замын хөдөлгөөн багасаж өглөө хүүхэд хүлээн авах орой тарах үед эцэг эхчүүд машинаа зогсоолд байрлуулах болон цэцэрлэгийн үүднээс хол машинаа тавьж хэвшиж байна.</p>	
2.5.4	Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, гэр бүлийн гишүүн бүрт зориулсан нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, эрсдэлт нөхцлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох ажлын хүрээнд “Хэрсүү гурвалжин” нөлөөллийн арга хэмжээг сумандаа хэрэгжүүлж эхлээд байна. Сумын цахим хуудас болон хүн ихээр зорчдог 13 ААНБ болон үйлчилгээний газруудын мэдээллийн самбарт “Харилцаа, хандлага, үйлдлээ эерэг болгоё”, “Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо бүү барь”, “Хүн л хүчирхийлэлд цэг тавьж чадна”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” “Хөршийн холбоогоо сайжруулж хүчирхийлэлгүй сум болцгооё” зэрэг сэдвүүдээр тараах материал, гарын авлага бэлтгэн байршууллаа.	90%
2.5.5	Залуучуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хөдөөгийн залууст нөлөөллийн ажлыг хэрэгжүүлнэ.	2021 ны 12 дугаар сарын 01-ний өдөр " Залуу малчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд 15 залуу малчдын төлөөлөл оролцсон бөгөөд зөвлөгөөнөөр Татварын байцаагч, Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн Нийгмийн даатгалын байцаагч, ХАА-н тасаг хамтран дэмжин туслах, нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.	90%
2.5.6	Аж ахуйн нэгж, албан байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд залуучуудын амьдрах орчин, боловсрол, гэр бүлд оруулах дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	Тус сумын Шинэбадрах ХХК Цэцэрлэгт 15м3, 30 иргэнд 140.64м3 Бүтээлийн нуур ХХК Цэцэрлэгт 15м3, Агро эрхтэй ХХК 20м3, Атартрейд ХХК 20м3, 110 иргэнд 110 300м3, Эмнэлэг 11.2м3, Номунхан ХХК 4.5м3 тус тус нийт сумын хэмжээнд 140 иргэн 440.64м3, 5 ААНБайгууллага , 85.7м3 мод, модон материалыг	90%

		нийгмийн хариуцлагын хүрээнд сумын иргэд, өрхийн болон ЖДҮ эрхлэгчдийг мод, модон материалаар хангах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан	
2.5.7	Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх ажлыг бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган сумын төсөвт байгууллагуудын албан хаагчдад “Жендэрийн тухай ойлголт”, “Төрийн захиргаан дахь жендэрийн асуудал” сэдвийн хүрээнд мэдээлэл хүргэж ажиллалаа. Сумын эмэгтэйчүүдийн салбар зөвлөлөөс “Эмэгтэйчүүдийн хүчирхийллийг таслан зогсоох, охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах” өдрийн хүрээнд Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн нөлөөллийн аяныг зохион байгуулан ажиллалаа.	90%
2.6.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал			
Иргэдийг аж ахуй эрхлэх ур чадварыг нь хөгжүүлж дэмжлэг үзүүлэн ажилтай, орлоготой болгоно.			
2.6.1	Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжтэй бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Шинээр 65 ажлын байр бий болсон. 2022 оны хагас жилийн байдлаар 80 шинэ ажлын байр бий болсон.	90%
2.6.3	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, ажилгүй иргэдийн тоог бууруулна.	2021 онд ажилгүй 99 иргэнг мэдээллийн санд бүртгэж 65 иргэнг ажлын байранд зуучилсан. Цар тахалын үед аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөрт авто засвар үйлчилгээ эрхлэгчийн ажлын байрыг дэмжиж 2 иргэнд 8 сая төгрөгийн эргэн төлөлттэй зээлд хамруулсан. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Санхүүгийн дэмжлэгт: тус 2-р багийн иргэн Б.Цэцгээ “Уран шаглаа” оёдолын төслөөр 5 сая төгрөг, 2-р багийн иргэн Н.Сэрээням “Талх”-ны цэхээр 10 сая төгрөгийн төслийг ХХҮГ-т бичиж хүргүүлэн дэмжигдсэн. Төсөлд хамрагдсан иргэд төслийг гэрээгээ хийгээд санхүүжилтээ хүлээж байна.	90%
2.6.5	Ахмад настны хөгжил, хамгааллын үйл ажиллагааг тогтмолжуулан, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.	2021 онд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2 өрх хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаанд шинээр хамрагдсан.	90%
2.6.6	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд	Шинээр 33 малчин иргэн сайн дурын даатгалд	90%

	болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	даатгуулсан. 2022 оны эхний хагас жилд шинээр малчин 16, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 26 даатгуулагч хамруулсан.	
2.6.7	Сайн дурын даатгалд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.	Шинээр 39 даатгуулагч иргэн сайн дурын даатгалд даатгуулсан. 2022 оны эхний хагас жилд шинээр 42 иргэн сайн дурын даатгалд хамруулсан.	90%
2.6.9	Иргэн бүрийг эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах ажлыг зохион байгуулна.	605 хүнд хөнгөлөлттэй эмийн жороор үйлчилсэн. 2022 оны эхний хагас жилд 995 хүнд 28,706,745 төгрөгийн хөнгөлөлттэй эмийн жороор үйлчилсэн байна.	90%
2.6.10	Тусгай хэрэгцээт иргэдийг хөгжүүлж, оролцоог ханган, ээлтэй орчин, хөдөлмөрлөх нөхцөл, боломжийг сайжруулна.	ОНОТХҮйлчилгээгээр зорилтод бүлгийн 2 өрх хүнсий ногооны төсөл хөтөлбөрт хамрагдаж амьжиргааны түвшин тодорхой хэмжээгээр нэмэгдсэн.	90%
Гурав. Эдийн засгийн бодлого 3.1.Хөдөө аж ахуйн бодлого			
Байгальд ээлжтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон цогц, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл авулгүй хүнсний хангамжийг сайжруулна.			
3.1.1	Атрын 4-р аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Улаан буудай 21310 га талбайгаас 30,822 тонн хураан авч га-н дундаж 14,4цн байна. Арвай 2442 га талбайд тариалснаас 51 га талбайг хурааж 107 тонн-г хураан авсан. 2391 га талбай нь тэжээлийн ургамалд шилжсэн байна. Овьёос 1239 га талбайд тариалснаас 735 га талбайг хурааж 1432 тонн ургац хураан авсан байна. Техникийн ургамал /рапс/ 12,325 га талбайд тариалснаас 10334 га талбайг хурааж 9444 тонн ургац хураан авч 1988 га- талбайг малын тэжээлд шилжүүлсэн байна. Төмс 130 га-д тариалснаас 1613 тонн ургац хураан авсан байна. Хүнсний ногоо 89 га талбайд тариалснаас 699,62 тонн ургац хураан авсан байна.	90%
3.1.2	Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас, хашаажуулах төслийг хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний байгууллагууд, төр,	Сэлэнгэ аймгийн мэргжилийн хяналтын газарт 9-н Аж ахуй нэгжийг үрийг мэргэжилийн хяналтийн газар хүргүүлэн үрийн дээжийн шинжилгээний хийлгэн сорилд оруулж 98% ургалт сайн гэсэн дүгнэлт гарсан. Шинжилгээгээр орсон сорт: Дархан 144, Бурьяский	90%

	хувийн хэвшлийн оролцоотойгоор ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.	оститая ХААЯ-наас хөнгөлтэй үнийг иргэн аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн Хамрагдсан 1 ААН, 107 өрх хамрагдлаа. Үрэнд сонгино 2,600кг Сармис 150кг лууван 5,5 кг хүрэн манжин 1 кг, шар манжин 0,5гр хөнгөлтэй үнээр олгов.	
3.1.3	Усалгаатай тариаланг хөгжүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран услах боломжтой талбайн судалгааг хийж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	2 аж ахуйн нэгж байгууллага нийт 2458 га талбайг усалгаажуулах хүчин чадал бүхий услалтын системийг ашиглаж байна	90%
3.1.5	Хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжиж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.	Хүлэмжийн болон зоорины аж ахуйг дэмжих зорилгоор 2021 онд нийт 6 өрхөд хөнгөлөлтэй нөхцөлөөр хүлэмж олгосон. Мөн сумын төвд байрлах иргэдийн хүнсний ногооны зооринд хяналт хийн ажилласан.	90%
3.1.6	"Жимс жимсгэнэ" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, тариалах талбайн хэмжээ, нэр төрлийг олшруулж, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	"Жимс жимсгэнэ" хөтөлбөрийн хүрээнд 1 иргэнд Согоочийн хөндийд 5га газар олгож жимс жисгэнэ тариалсан	90%
3.1.7	Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн суурин, хагас суурин мал аж ахуйг эрхлэн бэлчээрийн мал аж ахуйгаас татгалзаж "Сэлэнгэ мах", "Сэлэнгэ сүү", "Нарийн нарийвтар ноост хонь" төслийг хэрэгжүүлнэ.	Сумын ИТХ-д "Газар тариалангийн бүс нутагт МАА эрхлэгчдэд батламж олгох журам"-ын төслийн эхний хэлэлцүүлгийг хийж, 2-р хэлэлцүүлэгт бэлтгэв.	70%
3.1.8	Сэлгээн дэх таримлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх замаар тариаланд ашиглагдах боломжтой атар болон атаршсан газрыг эргэлтэнд оруулан тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж, баяжуулсан тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Гацуурт ХХК 663 га-д, Сэлэнгэ тариа ХХК 144 га-д, ТОВхонхан ХХК 31 га-д тэжээлийн ургамал тариалсан.	90%
3.1.9	Мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.	2021 оны 04-р сарын 29-ний өдрийн сумын Засаг даргын А/49 тоот захирамжийн дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 63000 толгой хурга, ишиг, Боом бод-29936, бог-27600 толгой, Цусан халдварт 12902 толгой үхэр, Коли иж балнад 704 толгой тугал, Дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 7800 толгой үхэр, Адууны сахуу – 2316, Адууны томуу-1600, ГЦХИБ-897, гахайн мялзан –1100 Галзуу-800 нохой, Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 40000 толгой хурга ишиг, 5200 толгой тугал тус тус хамруулж цахим системд шивж	90%

баталгаажуулсан.

3.2. Байгаль орчин:

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.1	Ус, хөрсийг хамгаалж, цөлжилт, бэлчээрийн доройтлоос сэргийлэн ойн зурвасыг нэмэгдүүлнэ.	Ойн мэргэжлийн ААН-үүд өөрийн хөрөнгөөр 2021 онд хийх ойжуулалтыг 2020-2021 онд үйлдвэрлэлийн огтлолтоор мод бэлтгэл хийсэн талбайд, аймгийн БОАЖГазрын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн ойжуулалтыг 2012 онд ойн хээрийн түймэрт өртсөн болон ойн цэвэрлэгээний унанга ихтэй талбайд хийж гүйцэтгүүлсэн. Тус суманд ААНБайгууллага өөрийн хөрөнгөөр Шинэбадрах ХХК 48.6 га, Бүтээлийн нуур ХХК 24.5 га тус тус ойжуулалтыг гүйцэтгэсэн байна. Улсын төсвийн хөрөнгөөр Ойн хүрэм ХХК 70га-д ойжуулалт хийсэн. 2022 оны байдлаар Шинэбадрах ХХК нь, Бүтээлийн нуур ХХК нь Хүрмэн ой ХХК-иар ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн. -Бүтээлийн нуур ХХК Сангалтайд 20 га талбайд шинэс модны суулгацаар, Шинэ бадрах ХХК Гүн шүрэнд 20 га талбайд шинэс модны суулгацаар хийсэн. Сумын хэмжээнд Иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-32 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-68 ширхгийг тарьсан байна. Нийт шилмүүст мод-188 ширхэг, гоёлын мод-103 ширхэг, жимсний мод-100 ширхгийг тарьсан байна.	90%
3.2.2	Ойн хөнөөлт хортон шавжийн олшрол, тархалтын судалгаанд тулгуурлан устгах ажлыг зохион байгуулна.	Ойн хөнөөлт ойн хөнөөлт хортон шавжийн олшрол, тархалтын судалгаанд ОйСХТ УТҮГазар 15500 га талбайд Нянгай, Хуурай хөндий, Баруун гол, Цог өндөр, Мандал овоо хөндий, Номгон толгой, Мойлт нуга, Шүрэнгийн адаг, Гангат, Хар усны үзүүр зэрэг газруудад судалгаанд хамтарч ажиллалаа. 2021 оны намрын судалгаагаар Бургасны бүгэгт Тамгын хоолойгоос Шүрэн хүртэл 1000 га талбайд хийж гүйцэтгэх ажлын саналыг аймгийн БОАЖГазарт хүргүүлсэн.	90%
3.2.3	Ойгоос мод бэлтгэх хуваарь мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтыг цахим хэлбэрт	Хийгдээгүй.	0%

	шилжүүлнэ.		
3.2.4	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлж, хилийн шороон зурвасыг сэргээх ажлыг зохион байгуулна.	Тус сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/27-тоот “Ой хээрийн түйрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээний тухай” захирамжаар Ой хээрийн түймрийн үед Гамшгаас хамгаалах штабын Аврах бүлэгт 1 дүгээр ээлжинд ажиллах ажилтнуудыг тушаал шийдвэрээр баталгаажуулан Гамшгаас хамгаалах штабт ирүүлэн шаардлагатай тохиолдолд байгууллагын хүн хүч, техник хэрэгслийг шуурхай дайчлан ажиллахад бэлэн байхыг сумын бүх байгууллага аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгон сургалтыг зохион байгуулан ажилласан. Хаварын хуурайшилтын үеийн бэлэн байдлыг ханган ажиллах ажлын хүрээнд байгаль хамгаалагч нар түймрийн үлээгч болон бусад хэрэглэгдэх багажнуудыг засаж, сэлбэх ажлыг хийж гүйцэтгэж бэлэн байдлыг хангаж ажилласан. Сумын хэмжээнд байгаль хамгаалагч нар тус тусын хариуцсан бүс нутгийн 211 малчин өрхийн 427 иргэнд, 8 ААНБайгууллагад ойн тухай хууль, хог хаягдлын тухай хууль, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, ан амьтны тухай хууль багтаасан САНАМЖ тарааж гарын үсгийн баталгаа авч ажилласан	90%
3.2.6	Аймгийн хэмжээнд нэн ховор, ховор ан амьтан болон Хараа, Ерөө голуудын загасны судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Хэрэгжиж эхлээгүй байна.	0%
3.2.7	Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Зэлтэр- Цагааннуур- Зүүнбүрэн чиглэлийн хатуу хучилттай зам тавих ажилд займын хайрга, дайрга авах карьерт хяналт тавин ажиллаж байна.	70%
3.2.8	Түүхэн болон байгаль экологи, эдийн засгийн хувьд ач холбогдолтой газар нутгийг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.	1-р багт байрлах Нинжидолби Номунханы хийд, Хүрэл зэвсгийн үеийн хадан дээрхи зосон зураг, бичээс, 3-р багт байрлах Дэмбэрэлийн хөшөөний тухай мэдээлэл бэлтгэн “Цагааннуур сумын байгаль орчин” пэйж хуудсаараа дамжуулан нийт давхардсан байдлаар 4502 хүнд хүргэсэн байна.	90%
3.2.9	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулж аюултай хог хаягдлыг түр хадгалах,	Хогийн цэгт иргэд хогоо асгах зам талбай гаргуулах ажилд Бүтээлийн нуур ХХК-тай 2021 оны 01-р сараас	90%

	устгах байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	<p>эхлэн гэрээ байгуулан дотор талд нь 3 удаа зам талбай гаргах явцад хяналт тавин ажиллалаа. Мөн гаргасан зам талбайд иргэд хогоо эмх цэгцгүй буулгахаас сэргийлж байгаль хамгаалагчид багийн Засаг дарга нартай хамтран 2-р сард ээлж гарган иргэдийн хог асгалтанд нь хяналт тавин шахуулж асгуулж ажилласан. Мөн 6-р сард Монгол ЛЗ зам гүүр ХХК-тай хамтран хогийн цэгийн гадна асгасан хог хаягдлыг түрж цэвэрлэхэд хяналт тавин ажиллалаа.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Сумын Засаг даргын А/37 тоот “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжын дагуу 2022 оны 03 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулан ЗДТГ-ын 4 ажилтан албан хаагчид, Хүнсний талонд хамрагддаг 14 иргэд, Худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэд, 9 аж ахуй нэгж байгууллагуудаас 120 иргэн, нийтдээ 160 иргэн хог цэвэрлэгээнд оролцож ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх 1,3 км засмал замыг цэвэрлэж нийт 4 тн хогийг хогийн нэгдсэн цэгт буулгалаа.</p>	
3.3. Аялал жуулчлал:			
Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийг хангаж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн жуулчдын ая тухтай амрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.			
3.3.2	Байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан НИТАЖ /нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал/-ыг хөгжүүлнэ.	Сумын төв талбай дээрх “Атар-50” хөшөө, Тамгын хоолой дахь дурсгалын гэрэлт хөшөөний хашааг сэргээн засварласан.	90%
3.4. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ:			
Худалдаа үйлчилгээний газруудыг орчин үеийн эрүүл ахуй, стандартын шаардлага хангуулж, үйлчилгээний чанар, харилцааны соёл дээшлүүлэх, аймаг, сум, багийн түвшинд ахуйн үйлчилгээг хөгжүүлж, нэр төрөл, чанар хүртээмжийг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулан үйлдвэрлэл үйлчилгээний төвүүдийг бий болгоно.			
3.4.1	Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ” арга хэмжээг төр, хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.	2021 оны 06 сарын 13-ны өдөр Нарийн боов, торт кекс хийх үйлдвэрлэл болон үйлчилгээний зориулалтаар Нуурын хишиг цехийн үйл ажиллагаа, 2 дугаар багт машин засвар, дугуй засварын газар, Усанболор 8 нэрийн барааны дэлгүүр эхлүүлэн нийт 3 үйлчилгээ шинээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 онд 2-р багт Очир мини маркет дэлгүүр шинээр үйл ажиллагаа	90%

		эхлүүлсэн.	
3.4.2	“Сэлэнгийн брэнд” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн, дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ.	Сум орон нутагтаа үйлдвэрлэж буй талх, нарийн боов 5, хэрчсэн гурил 3, Сүү цагаан идээ 3, зайрмагны цех 1, зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй газрууд Нуурын хишиг, Хуурч сүрэг хоршоо, Усанболор талх нарийн боовны цех, зэрэг газруудад хаяг шошго, он сар өдөр хадгалах хугацааг тогтмол тавьж худалдаанд гаргах зааварчилгаа, зөвлөмжийг өгч ажилласан. Мөн дээрх үйлдвэр үйлчилгээний газруудын бренд бүтээгдэхүүний нэр төрөл тоо хэмжээ нэмэгдэж иргэдэд худалдан борлуулж байна. 2022 оны хагас жилийн байдлаар талх, нарийн боовны цех 2, хэрчсэн гурил 3, сүү цагаан идээ 3, зайрмагны цех 1 зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй газрууд Нуурын хишиг, Өгөөж буян, Цэцэгхэн, Хуурч сүрэг хоршоо, Товхонхангай хоршоо, Арвин, Шинэ амт зэрэг газруудад хаяг шошго, он сар өдөр хадгалах хугацааг тогтмол тавьж худалдаанд гаргах зааварчилгаа, зөвлөмжийг өгч ажилласан. Мөн дээрх үйлдвэр үйлчилгээний газруудын бренд бүтээгдэхүүний нэр төрөл тоо хэмжээ нэмэгдэж иргэдэд худалдан борлуулж байна.	90%
3.4.3	Баялаг бүтээгч иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих аяныг өрнүүлнэ.	Худалдаа үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулан үйлчилгээний соёл, хүний нөөцийг чадавхжуулах мэдээ мэдээлэл зөвлөмж зэргийг цахим орчинд сурталчилан ажилласан. 2022 онд Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй газруудад хүнсний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалтад хамруулсан.	70%
3.4.5	Худалдаа үйлчилгээний салбарын орчин нөхцлийг сайжруулан үйлчилгээний соёл, хүний нөөцийг чадавхжуулна.	Худалдаа үйлчилгээ, цайны газрууд Хөдөлмөр хамгааллын хувцсаар жигдэрч үйлчилгээ үйл ажиллагаагаа явуулж байна. Ахуй үйлчилгээнээс халуун усны газар дотор орчин нөхцлийг сайжруулах их засварын ажил хийгдэж дотор орчин нөхцөлөө сайжруулсан. Төхижилт ногоон байгууламж аяны хүрээнд худалдаа үйлчилгээнээс Шинэ нуур элгэмсэг дэлгүүр нь 10 ш нарс, шар хуас 70 ш, жимсний мод	90%

		интоор 3, үхрийн нүд 3, монос 2 зэрэг гадна дотно орчиндоо тарьсан байна. Аамий таамий барааны дэлгүүр, Урианхайн шүрэн уул тун фарм эмийн сан зэрэг газрууд өөрийн эзэмшлийн гадна талбайг цементлөж сайжруулсан. Ноён-Уул ХХК нь ногоон байгууламжыг нэмэгдүүлэн хашаажуулан 15 мод тарьсан. Хос гялбаа үсчин, талх нарийн боовны цех зэрэг газрууд гадна хаягаа шинэчилсэн байна. Мөн худалдаа үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулан үйлчилгээний соёл, хүний нөөцийг чадавхжуулах мэдээ мэдээлэл зөвлөмж зэргийг цахим орчинд сурталчилан ажилласан. 2022 онд 1 цайны газар, 1 хүнсний дэлгүүрийн гадна хаяг шинэчлэгдсэн. Хүнсний дэлгүүрийн худалдагч боло ажилчид хувцаслалтаар жигдэрч Элгэмсэг дэлгүүр энгэрийн тэмдэгтэй болсон. Хүний нөөцийг чадавхжуулах мэдээ мэдээлэл, зөвлөмж зөвлөгөө зэргийг цахим орчинд сурталчлан мөн биечлэн танилцуулж ажилласан.	
3.4.6	Нийтийн хоолны үйлдвэр, үйлчилгээний ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч, сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн хоол зүйчтэй болгоно.	Мэргэжлийн хоол зүйчтэй болоогүй.	0%
3.4.7	“Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Коронавируст халдварын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллагууд, талхан цех 3, мөн шинээр хэрчсэн гурилын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 3 иргэнд хяналт тавьж холбогдох стандартыг мөрдүүлэн зааварчилгаа, зөвлөмж, мэдээ мэдээллийг хүргэж, мөн өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж аюулгүй байдлаа ханган ажиллаж байна. Тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар ярилцан санал бодлыг нь сонсон газар дээр нь биечлэн уулзаж ажиллалаа. Талх нарийн боов үйлдвэрлэгч, хэрчсэн гурилын цех 3 аймгийн МХГ-ын лабораторуу хүнсний дээжээ шинжилгээнд хамруулан ажилласан.	90%
3.4.8	Барилгын материалын хийц, эдлэл үйлдвэрлэх санал, санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд Сум хөгжүүлэх сангаас Блокны үйлдвэрлэл эрхлэх	90%

		зориулалтаар 3, явган хүний зам буюу зиг заг зам үйлдвэрлэлийн зориулалтаар 1 иргэнд нийт 46 сая төгрөгний хөнгөлтэй зээл олгосон.	
3.5.Хөрөнгө оруулалт, дэд бүтэц:			
Хүн амын орон сууц, эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.			
3.5.3	Ардын хувьсгалын 100 ижлийн ойг тохиолдуулан түүхэн болон дурсгалт газруудыг сэргээн засварлаж, тохижуулна.	Сумын төв талбай дээрх “Атар-50” хөшөө, Тамгын хоолой дахь дурсгалын гэрэлт хөшөөний хашааг сэргээн засварласан.	90%
3.5.7	Сумдад үерийн далан засварлах, гүүр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамж Үйлчилгээний газар, Цагааннуур сумын Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулан 2021 оны 10 сарын 07-ноос эхлэн үерийн далан шуудуу ухах цэвэрлэх ажлыг 5 хоногийн хугацаатай зохион байгууллаа. Уг нийтийг хамарсан ажилд сумын хөдөлмөр эрхэлдэггүй 10 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж түр ажлын байраар ханган ажилууллаа. Нийтийг хамарсан уг ажлын хүрээнд сумын 2-р багт байршилтай Гурван гүүрний сэтэрсэн даланг засварлаж, ойр орчимд цэвэрлэгээ хийлээ. Цагааннуур-Зүүнбүрэн-Түшиг чиглэлийн автозамын ажил хийгдэж байгаатай холбоотой сумын төвийн нутаг дэвсгэр дээр 5 гүүрэн гарц хийгдсэн байна.	90%
3.5.8	Агаарын хөлөг хөөрч, буух зурвас байгуулж, нислэг үйлдэх хэвийн үйл ажиллагааг хангана.	Иргэний нисэхий ерөнхий газраас ирсэн мэргэжилтнүүдтэй хамтран агаарын хөлөг хөөрч буух 160 метрийн өргөнтэй 300 метрийн урттай газарт хэмжилт хийж нислэг үйлдэхэд хэвийн үйл ажиллагааг хангахад орон нутгаас анхаарч ажиллах талаар өгсөн чиглэлийг Засаг даргад танилцуулсан.	70%
3.6. Санхүү, төсвийн зохицуулалт			
Төсвийн ил тод байдал, сахилга батыг хангаж, төсвийн төлөвлөлтийн оновчтой хуваарилалт, зарцуулалтыг удирдан, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулж, иргэд олон нийтийн санхүү, төсвийн мэдлэгийг дээшлүүлнэ.			
3.6.1	Эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурласан төсвийн төлөвлөлтийг оновчтой зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтын системийг сайжруулж, үр дүнгийн шинжилгээнд суурилан төсвийн ил тод байдлыг	2021 оны 12 сарын байлаар Төсвийн тухай хуулийн дагуу Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 3 удаагийн төсвийн тодотгол хийгдэж, төсвийн ерөнхийлөн захирагчийн сар, улирлын хувиарлалтад 6 удаа төсвийн	90%

	хангана.	зохицуулалт хийж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгон санхүүжүүлж байна. Төсвийн хэмнэлтийн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн төсвийн төлөвлөлтийг хэмнэлттэй оновчтой зохион байгуулж, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон төсвийн хуваарилалт, төсвийн төсөл, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө тусламжаар хийгдсэн арга хэмжээ болон бусад мэдээллийг төсөвт байгууллага бүрээр тухай бүр сумын албан ёсны цахим хуудас /tsagaannuur.se.gov.mn/ болон мэдээллийн самбарт байршуулж, иргэд олон нийтийг шинэчлэгдсэн мэдээлэлтэй нээлттэй, чөлөөтэй танилцах боломжоор ханган ажиллаж байна.	
3.6.2	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийж, үйл ажиллагааг сайжруулна.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 29 тоот тогтоолоор Орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зас талбайн тохижилт үйлчилгээ, ногоон байгууламж, авто зам, цэвэр бохир ус, барилга байгууламжийн ашиглалт зэрэг нийтийн үйлчилгээг бүхэлд нь үзүүлэх чиглэлтэйгээр 2021 оны 03 сарын 23-ны өдөр “Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ-ыг байгуулж, үйл ажиллагаагаа 2021 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн явуулж байна. Энэ ажлын хүрээнд сумын Цагааннуур тохижилт ОНӨААТҮГ-руу хөрөнгө шилжүүлэх, үйл ажиллагааг дэмжин орон нутгийн хөгжлийн сангаас болон төсвийн хөрөнгөөр бохир сорох машин, услалтын системийн тоног төхөөрөмж худалдан авч шилжүүлсэн.	90%
3.6.3	Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, тайлагналт, үйл ажиллагааг цахимжуулж, хуулийн хүрээнд татвар ногдуулах боломжийг эрэлхийлж татварын суурийг нэмэгдүүлнэ.	2020 онд УИХ-с баталсан малын тоо толгой алба татварын тухай хууль 2021 оны 1-р сарын 1-с хэрэгжи эхэлсэнтэй холбоотой татварын суурь бааз МТТАТ-70 ХХОАТ-400, нийт 1100 татвар төлөгчөөр нэмэгдсэн байгаа орон нутгийн төсөвт МТТАТ 119,985,2 мянган төгрөг төвлөрхөөс 65.999.8 мянган төгрөг буюу 55%-тай байна ХХОАТ 48,583.4 мянган төгрөг төвлөрхөөс 61,217.9 мянган төгрөг буюу 126%-тай биелсэн байна	90%
3.6.4	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт,	Нийт 8 төсөвт байгууллагын хүний нөөц удирдлага мэдээллийн санд бүртгэлтэй 203 төрийн албан хаагчдын мэдээллийг шалгаж, төрийн албаны цалингийн нэгдсэн	90%

	хяналтыг сайжруулна	системд холбож, төрийн албаны цалингийн нэгдсэн системээс боловсруулагдаж гарсан төлбөрийн хүсэлтийг үндэслэж цалингийн олгож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэнд хяналт тавин, цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгон ажиллаж байна.	
3.6.5	Статистикийн мэдээ, тооллого, судалгааг үнэн, бодитой хийж, үр дүнгийн шинжилгээнд суурилсан мэдээллийг хэрэглэгчдэд боломжит хэлбэрээр тархааж, бодлогын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.	Албан ёсны 48 төрлийн статистик мэдээг нийт 247 удаагийн давтамжтайгаар холбогдох мэргэжилтнээр үнэн зөв бодитой гаргуулан графикийн дагуу цаг хугацаанд нь аймгийн статистикийн хэлтэст цаасаар болон онлайнаар хүргүүлэн үр дүнг хэрэглэгчдэд тархаасан. 2022 оны байдлаар албан ёсны 18 төрлийн статистик мэдээг 40 удаагийн давтамжтайгаар холбогдох мэргэжилтнээр үнэн зөв бодитой гаргуулан аймгийн статистикийн хэлтэст хүргүүлэн статистикийн мэдээллийн самбар болон гарын авлагаар дамжуулан хэрэглэгчдэд тархааж байна.	90%
3.6.6	“Иргэн та эдийн засагч” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Иргэн та эдийн засагч” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу татварын байцаагч, нийгмийн даатгалын байцаагч, ХАА-н мэргэжилтэнтэйгээ хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, малчид хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай, татварын боловсрол олгох тухай, бизнес төлөвлөгөө, төсөл хэрхэн бичих, орчны шинжилгээ гарааны биенес эхлэхэд зориулсан зөвлөгөө, сум хөгжүүлэх сангийн зээл, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн зээлийг талаарх ойлголт, Статистикийн боловсрол болон санхүүгийн эдийн засгийн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулсан. Мөн малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд “Татвар төлөгчдийн өдөр-ийг” зохион байгуулсан. Мөн Цагааннуур сумынхаа цахим хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын тухай ойлголт, татварын тухай ойлголтууд болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон бусад мэдээллүүдээр иргэд олон нийтийг шинэчлэгдсэн мэдээлэлтэй нээлттэй, чөлөөтэй танилцах боломжоор ханган ажиллаж байна.	90%
Дөрөв. Засаглалын бодлого 4.1.Нутгийн захиргаа			

Төрийн үйлчилгээнд ухаалаг-тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.			
4.1.1	Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.	Төрийн албан хаагчийг ажлын байранд нь чадавхжуулах, харилцаа, хандлага, ажлын үр дүн, гүйцэтгэл, ур чадварыг нэмэгдүүлэх онол, практик, олон улсын туршлагын шинэ мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 32 удагаайн сургалтад цахимаар хамрагдсан.	90%
4.1.2	Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, төрийн бүх шатны байгууллагад суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлнэ.	Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Багийн Засаг дарга нарын зөөврийн компьютерийг 4,5 сая төгрөгийн өртөгтэйгээр, ажлын ширээг 1,5 сая төгрөгийн өртөгтэйгээр бүрэн шинэчилсэн.	90%
4.1.3	Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах бэлтгэл ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.	“Монгол бичиг үндэсний хөтөлбөр-III” хүрээнд төсвийн байгууллагын ажилчдаас үндэсний бичгийн мэдлэгийн талаар тандалт судалгааг онлайнгаар авч нэгтгэн түүний дагуу төсвийн ажилчдад ээлж дараалан үндэсний бичгийн анхан шатны сургалтыг зохион явуулж эхэлсэн. Үүнд 1-р цэцэрлэгийн 28 багш ажилчдад анхан шатны 1 сарын сургалтыг зохион байгуулж хамрагдсан багш ажилчдадаа сертификат олголоо.	90%
4.1.4	Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хэрэгжүүлж, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.	E-mongolia цахим системийг операторын горимоор ажиллуулж 16 төрлийн лавлагаа мэдээллийг давхардсан тоогоор 223 иргэнд үзүүлсэн байна.	90%
4.1.5	Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан “Таныг сонсьё” арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, захиргааны шийдвэр гаргах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Сумын төр, төсвийн байгууллагуудад иргэдээс нийт 68 өргөдөл, гомдол ирснийг 100% хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна. Сумын малын тоо толгойн албан татварыг тогтоох шийдвэрт саналыг нийт малчин 160 малчин өрхөөс утсаар авч дүнг нэгтгэн хуралд танилцуулж батлуулсан.	90%
4.1.7	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх мэдээллийн дэд бүтцийг хэрэглээнд нэвтрүүлнэ.	Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцоонд Able, Төрийн байгууллагын цахим шуудан email.gov.mn цахим систем ашиглаж байна.	90%
4.1.8	Орон нутгийн төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичигт төлөвлөлт, явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг тооцох тогтолцоог	Төсөвт байгууллагуудад санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Санхүүгийн албаны даргаар ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 1 болон 3-р улиралд дотоод хяналт шалгалтыг хийсэн. Мөн Сумын засаг	90%

	бэхжүүлнэ.	даргын 2021 оны 10-р сарын 18-ны өдрийн №А/111 тоот захирамжийн дагуу ЗДТГДҮТОГүйцэтгэгчээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Эрүүл мэндийн төв болон Ерөнхий боловсролын сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж,Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөвт байгууллагуудын дарга нарт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
4.1.9	Баг, тосгодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна.	Багийн Засаг дарга нарын зөөврийн компьютерийг 4,5 сая төгрөгийн өртөгтэйгээр, ажлын ширээг 1,5 сая төгрөгийн өртөгтэйгээр бүрэн шинэчилсэн.	90%
4.1.12	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоо, мэргэжлийн байгууллагын бэлэн байдлыг ханган, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлж, шаардлагатай сумдад Онцгой байдлын тасаг, нэгжийг байгуулна.	Сумын Засаг даргын захирамжаар СОК, ГХШШ-ын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаж бэлтгэл, бэлэн байдлыг ханган УОК-с зарласан Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед бүрэн бүрэлдэхүүнээр ажилласан. Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага сурууль 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн өглөө 10:00 цагт түр цугларах талбайд, сургуулилтад 589 иргэн хамрагдлаа.	90%
4.2. Хууль эрх зүй			
Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар иргэн бүр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг төлөвшлийг бий болгож, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах ажлыг дээшлүүлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.			
4.2.1	“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах бодлого”-ыг боловсруулан хэрэгжүүлнэ.	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Төрийн болон албаны нууцын тухай хууль, терроризмын талаар байгууллагын албан хаагчдыг 2 удаа сургалтанд хамруулсан. Мөн төлөвлөгөөний дагуу сумын ундны	90%

		усны эх үүсвэр, гүний худагуудад аюулгүй байдалд хяналт тавих, суманд байгаа гадаад иргэдийн судалгааг шинэчлэн гаргах, хяналт тавих, сүм хийдийн судалгааг шинэчлэх гэх мэт ажилуудыг тухай бүр хийж байна.	
4.2.2	Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай хүргэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	Хувь хүний орлогын албан татвар, Авлигын эсрэг, Төрийн албан хаагчийн ёс зүй, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, Хүнсний эрхийн бичиг олгох журмын тухай 7 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 460 иргэнийг хамруулсан байна. “Эрх зүйн хөтөч”-ийн булангаар дамжуулан 1 иргэн цахимаар, 26 иргэн утсаар хууль зүйн зөвлөгөө мэдээлэл авсан.Хууль, эрх зүйн сэдэвт гарын авлага 200ш тараагдсан байна.	90%
4.2.3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	Цагааннуур сумын цагдаагийн хэсэг нэртэй цахим хуудсыг ажиллуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шторк, постыг тогтмол байршуулж байна. Мөн иргэдийн эрх зүйн боловсролд зориулан Зөрчлийн тухай хууль болон Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн талаар мэдээлэл байргуулж ажилласан.	90%
4.2.4	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээн авлига, албан тугаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх , авлигын хор аюулыг ухуулан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Зөв зөвд шударга зөв” нөлөөллийн аянд нэгдэж аяны талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэсэн. Соён гэгээрүүлэх аяны хүрээнд 12 төрлийн сурталчилгааны хуудас, 9 төрлийн зөвлөмж, 14 видео бичлэг сумын цахим хуудаст байршуулсан.“Шударга Удирдагч, Шударга Төрийн албан хаагч” аяны удирдамжийг төсвийн байгууллагуудад хүргэсэн. Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 17 албан тушаалтныг 02 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь гаргуулж, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг зохих журмын дагуу хянуулсан. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар 1 удаагийн сургалт, 3 удаагийн цахим сурталчилгааг зохион байгуулсан.	90%

4.2.5	Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгож, иргэн бүрийн аюулгүй байдлаа хангах мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Иргэд, олон нийтийн хэрэгцээ сонирхлыг харгалзан хууль зүйн мэдлэг олгох, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалтыг зорилтот бүлэгт зориулан явуулах төлөвлөгөөний дагуу 7 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 460 иргэн хамрагдсан байна.	90%
4.2.6	“Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн улсын бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломж нөхцөлийг сумдад бүрдүүлнэ.	Улсын бүртгэлийн ерөнхий газар болон КОЙКА Олон улсын байгууллагатай хамтарсан Иргэний шинэчилсэн бүртгэлийн шинэ компьютер, принтер, канон, сканер, хурууны хээ уншигч, зургийн аппарат зэрэг иж бүрэн тоног төхөрөөмжийг хүлээн авч шинэ программаар ажиллаж байна. Шинэ тоног төхөөрөмж, шинэ програмтай нэвтэрснээс хойш хийсэн бүх төрлийн бүртгэлүүдийг цахимжуулалтанд оруулж цахим архив үүсгэн ажиллаж байна.	90%
4.3. Батлан хамгаалах			
Орон нутгийн хамгаалалтын тогтолцоо бэхжиж, батлан хамгаалах чадавх дээшилсэн байна.			
4.3.1	Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Цэргийн тоо бүртгэлийн үеэр шинээр 18 нас хүрсэн залуусыг бүртгэлд идэвхитэй хамруулах талаар багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж шинээр цэргийн үүрэгтний үнэмлэх бичиж олгох ажлыг зохион байгуулсан. 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Иргэний Андгай өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулж 16 нас хүрч иргэний үнэмлэх авсан 36 хүүхэд Иргэний Андгай өргөсөн. 2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагад татагдсан иргэдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан картыг сумын ЭМТ-ийн их эмч хариуцан авч 3 иргэнийг давтан шинжилгээнд хамруулж эмчилсэн. Аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-Спортын "Дөл" тэмцээн 2022.05.29-ний өдөр суманд зохион байгуулагдаж Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 3 бүлгийн 33 сурагч оролцсон. Мөн бүсийн тэмцээнийг сумандаа зохион байгуулж 3 сумын 36 сурагч оролцсон.	90%
4.3.4	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг зохион байгуулж, бүх нийтийн оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт	ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нараар дамжуулан иргэдэд батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах чиглэлээр үүрэг даалгавар өгч биелэлтийг хянан ажиллаж байна.	90%

	арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Холбогдох хууль дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу мэдээллийн самбар болон цахим хуудсаар мэдээллийг хүргэн ажилласан.	
Тав. Ногоон хөгжил			
Байгалийн унаган төрхийг хадгалж, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглан, байгальд ээлтэй үзэл санааг түгээн дэлгэрүүлнэ.			
5.1.1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих, мэдлэг олгоно.	Хэрэгжиж эхлээгүй байна.	0%
5.1.3	“Ногоон сум” хөдөлгөөнийг өрнүүлнэ.	“Ногоон сум” хөдөлгөөнийг айл өрх, ААНБ бүрийг мод, бут, сөөг тарих, зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлж. Сумын хэмжээнд 22 төрлийн 2688 ширхэг мод бут сөөг, 19 төрлийн 9600 ширхэг суулгасан.	90%
5.1.4	Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулна.	80,0 сая төгрөгийн өртөгтэйгээр зураг төсөв, газрын асуудлыг шийдвэрлэх шатандаа явж байна.	70%
5.1.5	Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.	Нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлгийн цагийн тохиргоог сар бүр хийж, асах унтрах хугацааг харанхуйтай уялдуулж зохицуулан ажиллаж байна. Мөн төр төсвийн байгууллагуудын уриалга санаачлагаар байгууллагын гаднах хэмнэлттэй лед болон мэдрэгчтэй гэрлүүд байрлуулан, цаашид нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Аймгийн замын сангийн 32,5 сая төгрөгийн өртөгтэй тендерт “Авто мастер төв” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Хил гааль хаагдсантай холбогдуулан гаднаас авах лед гэрлүүд орж ирэх боломжгүй байгаагаас гэрээг сунгах хүсэлт тавьсан байна.	70%
5.1.6	Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана.	12 төрлийн мэдээ мэдээллийг сумын цахим хуудсаар дамжуулан иргэдэд нөлөөлөн ажиллаж байна.	90%

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

2022.06.30

Цагааннуур сум

Зорилт арга хэмжээ	Заалт	2022 он /хувь					Дүн
		0	30	50	70	90	
НЭГ.“КОВИД-19” БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
Зорилт 1	11					11	90
Дүн	11					11	90
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Эрүүл мэнд	8				1	7	87,5
Боловсрол	6				1	5	86,6
Биеийн тамир, спорт	7				1	6	87,1
Соёл, урлаг	7	1				6	77,1
Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого	7				1	6	87,1
Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал	7					7	90
Дүн	42	1			4	37	85,9
ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
Хөдөө аж ахуйн бодлого	8				1	7	87,5
Байгаль орчин	8	2			1	5	65
Аялал жуулчлал	1					1	90
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ	7	1			1	5	74,2
Хөрөнгө оруулалт, дэд бүтэц	3				1	2	83,3
Санхүү, төсвийн зохицуулалт	6					6	90
Дүн	33	3			4	26	81,6
ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
Нутгийн захиргаа	9					9	90
Хууль эрх зүй	6					6	90
Батлан хамгаалах бодлого	2					2	90
Ногоон хөгжил	5	1			2	2	64
Дүн	22	1			2	19	83,3
Нийт дүн	108	5			10	93	85,2

НЭГТГЭЛ ХИЙСЭН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АЛТАНЗОРИГ

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Ц.БАЯНБААТАР